



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.10.10 № 36

Төрөөс олгож байгаа хөнгөлөлт,
чөлөөлөлт, татаасын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их хурлаас 1994 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр соёрхон баталсан “Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай” Олон Улсын хэлэлцээр, түүний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүрээнд 2012 оноос хойших хугацаанд Засгийн газраас хийж гүйцэтгэсэн ажлууд, тэдгээрийн үр дүнгийн талаарх мэдээлэл;

2. Аливаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгож буй татаас, хөнгөлөлт, давуу байдлуудын төрөл, түүний шалгуур, шийдвэр гаргах журам, тэдгээрийн хуулийн зохицуулалт болон тус шийдвэр, үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэх, мөн хэрэгжилтэд тавьсан хяналт, түүний үр дүнгийн талаарх 2012 оноос хойших мэдээлэл;

3. 2012 оноос хойших хугацаанд төрөөс олгосон татаас, санхүүгийн хөнгөлөлт, чөлөөлөлт, давуу байдлын хэмжээ, олгосон нийт дүнгийн талаарх мэдээлэл;

4. 2016 оноос хойш Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус бүрээр улсаас олгосон татаас, санхүүгийн чөлөөлөлт, хөнгөлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон уг татаас, чөлөөлөлт, хөнгөлөлтийг олгоход үндэслэл болгосон хууль тогтоомж, дүрэм журам;

5. Татаас, санхүүгийн хөнгөлөлт, чөлөөлөлт давуу байдлын талаар Засгийн газраас одоо баримталж буй бодлого болон цаашид ямар бодлого баримтлах талаар;

6. Аливаа салбар, чиглэл, иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн давуу байдал, хөнгөлөлт, чөлөөлөлт, татаас олгож болохоор зохицуулсан хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх журмын лавлагаа, мэдээлэл;


7. Монгол Улсад 2012 оноос хойш үйлчилж байсан болон одоо үйлчилж буй бүх төрлийн татаас, санхүүгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн төрлийн талаарх мэдээлэл, жагсаалт;

2022000084

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2022000094